ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянмөнх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ХЭА-2022/62/НА-СТА-ТШ3


Аудитын газрын Дарга,
тэргүүлэх аудитор: Ч.Эрдэнэбаатар
Утас: 70562112

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390

Аудитор: Х.Еркегүл
Утас: 99040705



Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Аудитын санал дүгнэлт....2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл....4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан....4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан....5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан....6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан....8
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан....9
3. Аудитын тайлан....10
3.1 Ерөнхий зүйл....10
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт....10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал....10
3.4 Материаллаг байдал....10
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....13
3.8 Аудитын гол асуудал....13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал....13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт....13
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт....13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....13
4. Аудитын илрүүлэлт....14
4.2.1 Залруулсан алдаа....14
4.2.2 Албан шаардлага....14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл....14
6. Албан шаардлага....15

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ЭМДС | Эрүүл мэндийн даатгалын сан |
| ЭМТ | Эрүүл мэндийн төв |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас:70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2022.02.25 № 70

танай ______ -ны № ______ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ
СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА С.НАНСАЛ ТАНАА

Аудитын санал дүгнэлт гаргах тухай

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянмөнх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагад төлөх 4.4 сая төгрөгийн эмийн өрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, цалингийн зардлыг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэдэггүйгээс санхүүгийн тайланд авлага 3.1 сая төгрөг, ХХОАТ-н өглөг 0.7 сая төгрөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

023030108

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН
ДАРГА С.НАНСАЛ ТАНАА

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Баянмөнх сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Байгууллагад төлөх 4.4 сая төгрөгийн эмийн өрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, цалингийн зардлыг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэдэггүйгээс санхүүгийн тайланд авлага 3.1 сая төгрөг, ХХОАТ-н өглөг 0.7 сая төгрөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, оршин байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

E:/DOTOOD AJIL/БХ 2022/явсан бичиг/А4 20220225 60

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ч.ЭРДЭНЭБААТАР

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **15,358,632.45** | **53,247,658.87** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 2,409,826.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 2,409,826.00 |
| **3121** | **Төгрөг** | - | 2,409,826.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 2,409,826.00 |
| **33** | **АВЛАГА** | 461,467.00 | 40,807,250.20 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 461,467.00 | 3,137,850.20 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | - | 37,669,400.00 |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | 784,000.00 | - |
| **3471** | **Урьдчилгаа тооцоо** | 784,000.00 | - |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 484,000.00 | - |
| 34713 | Цалингийн урьдчилгаа | 300,000.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 14,113,165.45 | 10,030,582.67 |
| **351** | **Түүхий эд материал** | 7,888,027.45 | 2,810,407.44 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 302,500.00 | 990,700.00 |
| 35130 | Эм боох материал | 7,585,527.45 | 1,819,707.44 |
| **354** | **Хангамжийн материал** | 5,485,138.00 | 6,530,175.23 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 172,940.00 | 172,940.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,929,200.00 | 5,349,200.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 382,998.00 | 1,008,035.23 |
| 35600 | Мал амьтад | 740,000.00 | 690,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **451,381,661.70** | **471,596,196.31** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 451,381,661.70 | 471,596,196.31 |
| **392** | **Биет хөрөнгө** | 441,465,661.70 | 461,680,196.31 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 422,749,062.00 | 422,749,062.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (30,284,629.87) | (41,207,810.83) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 31,051,841.00 | 35,700,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (15,525,920.46) | (1,189,999.86) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 63,824,868.07 | 86,416,658.16 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (38,612,230.50) | (46,458,674.54) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 18,910,872.56 | 18,910,872.56 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (10,648,201.10) | (13,239,911.18) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 224,543.00 | 224,543.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (224,543.00) | (224,543.00) |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 9,916,000.00 | 9,916,000.00 |
| 39301 | Програм хангамж | 372,100.00 | 372,100.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (372,100.00) | (372,100.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 9,916,000.00 | 9,916,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **466,740,294.15** | **524,843,855.18** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **33,825,336.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | 33,825,336.00 |
| **413** | **Өглөг** | - | 33,825,336.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 29,403,636.00 |
| **4136** | **Бусад өглөг** | - | 4,421,700.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | - | 4,421,700.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **466,740,294.15** | **491,018,519.18** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 466,740,294.15 | 491,018,519.18 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 316,754,924.75 | 316,754,924.75 |
| 51101 | Өмч: - төрийн | 316,754,924.75 | 316,754,924.75 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 58,895,101.42 | 83,173,326.45 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 58,895,101.42 | 58,895,101.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 24,278,225.03 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 91,090,267.98 | 91,090,267.98 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **466,740,294.15** | **524,843,855.18** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **343,218,663.50** | **535,757,268.32** |
| **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **8,195,823.50** | **56,534,672.32** |
| **Нийтлэг татварын бус орлого** | 8,195,823.50 | 56,534,672.32 |
| Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,195,823.50 | 56,534,672.32 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 93,897.00 | - |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,101,926.50 | 56,534,672.32 |
| **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **335,022,840.00** | **479,222,596.00** |
| Улсын төвлөрсөн төсвөөс | 306,385,300.00 | 351,810,800.00 |
| Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 306,385,300.00 | 351,810,800.00 |
| **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **3,605,000.00** | **47,036,596.00** |
| Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 46,450,396.00 |
| Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,605,000.00 | 586,200.00 |
| **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **9,496,000.00** | **26,773,100.00** |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 9,496,000.00 | 26,773,100.00 |
| **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | **15,536,540.00** | **53,602,100.00** |
| Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 15,536,540.00 | 53,602,100.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **380,691,007.79** | **504,141,083.13** |
| **УРСГАЛ ЗАРДАЛ** | **380,691,007.79** | **504,141,083.13** |
| **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **376,879,277.38** | **471,832,506.13** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **228,012,800.00** | **307,603,111.00** |
| Үндсэн цалин | 143,116,315.00 | 143,346,200.37 |
| Нэмэгдэл | 65,098,209.00 | 104,801,806.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 4,752,000.00 | 4,736,000.00 |
| Урамшуулал | 15,046,276.00 | 54,719,104.63 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **29,032,591.59** | **40,198,591.80** |
| Тэтгэврийн даатгал | 19,986,883.75 | 28,870,662.27 |
| Тэтгэмжийн даатгал | 2,269,868.49 | 2,774,806.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 1,816,154.99 | 2,214,885.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 450,853.31 | 260,841.68 |
| Эрүүл мэндийн даатгал | 4,508,831.05 | 6,077,396.85 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **8,259,242.00** | **15,873,743.00** |
| Гэрэл, цахилгаан | 1,909,242.00 | 1,669,151.00 |
| Түлш, халаалт | 6,290,000.00 | 13,872,392.00 |
| Цэвэр, бохир ус | 60,000.00 | 332,200.00 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **14,776,237.53** | **19,038,858.00** |
| Бичиг хэрэг | 846,900.00 | 2,357,200.00 |
| Тээвэр, шатахуун | 9,620,388.20 | 11,817,062.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,232,000.00 | 1,383,200.00 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 350,000.00 | 117,896.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,607,900.00 | 2,632,400.00 |
| Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,119,049.33 | 729,700.00 |
| Бараа материал акталсны зардал | - | 1,400.00 |
| **Нормативт зардал** | **29,880,022.18** | **44,280,241.01** |
| Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 22,163,422.18 | 33,338,041.01 |
| Хоол, хүнс | 7,360,000.00 | 7,642,000.00 |
| Нормын хувцас, зөөлөн эдлэл | 356,600.00 | 3,300,200.00 |
| **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,834,000.00** | **9,062,400.00** |
| Багаж, техник, хэрэгсэл | - | 2,500,000.00 |
| Урсгал засвар | 3,834,000.00 | 6,562,400.00 |
| **Томилолт, зочны зардал** | **1,257,000.00** | **2,155,686.00** |
| Дотоод албан томилолт | 1,257,000.00 | 2,155,686.00 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **25,313,051.00** | **632,580.00** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,777,191.00 | - |
| Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 432,000.00 |
| Даатгалын үйлчилгээ | 100,000.00 | - |
| Тээврийн хэрэгслийн татвар | 63,860.00 | 64,860.00 |
| Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 11,100.00 |
| Газрын төлбөр | 15,000.00 | 124,620.00 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **36,514,333.08** | **32,987,295.32** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 7,376,700.00 | 3,948,000.00 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 29,137,633.08 | 29,039,295.32 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,811,730.41 | 32,308,577.00 |
| **Бусад урсгал шилжүүлэг** | **360,000.00** | **24,640,500.00** |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 360,000.00 | 24,640,500.00 |
| **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **3,451,730.41** | **7,668,077.00** |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,451,730.41 | 7,668,077.00 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | (37,472,344.29) | 31,616,185.19 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **93,750.26** | **7,337,960.16** |
| Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 93,750.26 | 7,337,960.16 |
| **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **(93,750.26)** | **(7,337,960.16)** |
| **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(37,566,094.55)** | **24,278,225.03** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 316,754,924.75 | 91,090,267.98 | 58,895,101.42 | | 466,740,294.15 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **316,754,924.75** | **91,090,267.98** | **58,895,101.42** | - | **466,740,294.15** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | | - |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **316,754,924.75** | **91,090,267.98** | **58,895,101.42** | - | **466,740,294.15** |
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **316,754,924.75** | **91,090,267.98** | **58,895,101.42** | - | **466,740,294.15** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **316,754,924.75** | **91,090,267.98** | **58,895,101.42** | - | **466,740,294.15** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 24,278,225.03 | | 24,278,225.03 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **316,754,924.75** | **91,090,267.98** | **83,173,326.45** | - | **491,018,519.18** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **335,022,840.00** | **441,553,196.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **335,022,840.00** | **441,553,196.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 306,385,300.00 | 351,810,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 306,385,300.00 | 351,810,800.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 3,605,000.00 | 47,036,596.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 46,450,396.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 3,605,000.00 | 586,200.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 9,496,000.00 | 26,773,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 9,496,000.00 | 26,773,100.00 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 15,536,540.00 | 15,932,700.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 15,536,540.00 | 15,932,700.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **335,022,840.00** | **436,233,380.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **335,022,840.00** | **436,233,380.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **331,211,109.59** | **403,867,803.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 228,101,876.00 | 282,840,274.00 |
| 210101 | Үндсэн цалин | 143,205,391.00 | 136,395,461.00 |
| 210102 | Нэмэгдэл | 65,098,209.00 | 99,081,175.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,752,000.00 | 4,736,000.00 |
| 210104 | Урамшуулал | 15,046,276.00 | 42,627,638.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 29,056,869.59 | 37,934,176.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,011,161.75 | 26,935,847.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,269,868.49 | 2,749,557.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,816,154.99 | 2,199,606.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 450,853.31 | 549,951.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,508,831.05 | 5,499,215.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 8,406,079.00 | 15,873,743.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,909,242.00 | 1,669,151.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,290,000.00 | 13,872,392.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 206,837.00 | 332,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,490,439.00 | 18,268,158.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,200,000.00 | 2,450,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,208,439.00 | 11,817,062.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,232,000.00 | 1,383,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 350,000.00 | 117,896.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,500,000.00 | 2,500,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 18,339,595.00 | 33,181,287.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 9,256,095.00 | 22,103,087.00 |
| 210502 | Хоол, хүнс | 6,550,000.00 | 7,550,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,533,500.00 | 3,528,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,018,000.00 | 8,628,399.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 2,549,999.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,018,000.00 | 6,078,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 1,257,000.00 | 2,155,686.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,257,000.00 | 2,155,686.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 25,313,051.00 | 632,580.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,777,191.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 432,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 100,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 63,860.00 | 64,860.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 33,000.00 | 11,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 15,000.00 | 124,620.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,228,200.00 | 4,353,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,228,200.00 | 4,353,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,811,730.41** | **32,365,577.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 360,000.00 | 24,697,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 360,000.00 | 24,697,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 3,451,730.41 | 7,668,077.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,451,730.41 | 7,668,077.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | - | **5,319,816.00** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | **2,909,990.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **2,909,990.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 2,909,990.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 2,909,990.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | - | **(2,909,990.00)** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 2,409,826.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 2,409,826.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 395,403,100.00 | 384,438,817.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 395,403,100.00 | 384,438,817.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 394,403,100.00 | 383,441,317.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 276,287,600.00 | 274,064,584.00 |
| 210101 | Үндсэн цалин | 158,652,200.00 | 136,395,461.00 |
| 210102 | Нэмэгдэл | 89,049,600.00 | 97,181,265.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,788,000.00 | 4,736,000.00 |
| 210104 | Урамшуулал | 23,797,800.00 | 35,751,858.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 36,740,400.00 | 36,740,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,093,200.00 | 26,093,200.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,661,800.00 | 2,661,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,129,400.00 | 2,129,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 532,400.00 | 532,400.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,323,600.00 | 5,323,600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 23,538,100.00 | 15,873,743.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 2,801,000.00 | 1,669,151.00 |
| 210302 | Түлш, халаалт | 20,404,900.00 | 13,872,392.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 332,200.00 | 332,200.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 17,487,800.00 | 17,406,058.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,200,000.00 | 2,200,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 11,205,800.00 | 11,204,962.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,232,000.00 | 1,383,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 350,000.00 | 117,896.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 23,767,200.00 | 23,760,063.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 12,682,200.00 | 12,681,863.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,550,000.00 | 7,550,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,535,000.00 | 3,528,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 9,577,500.00 | 8,691,389.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 6,342,500.00 | 5,459,989.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,235,000.00 | 3,231,400.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,000,000.00 | 1,919,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,000,000.00 | 1,919,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 647,000.00 | 632,580.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 432,000.00 | 432,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 65,000.00 | 64,860.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 11,100.00 | 11,100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 138,900.00 | 124,620.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 4,357,500.00 | 4,353,500.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,357,500.00 | 4,353,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1,000,000.00 | 997,500.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,000,000.00 | 997,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 997,500.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 395,403,100.00 | 386,848,643.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 351,810,800.00 | 351,810,800.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 351,810,800.00 | 351,810,800.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 26,773,100.00 | 19,105,143.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 26,773,100.00 | 19,105,143.00 |
| **1340** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮ** | 16,819,200.00 | 15,932,700.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 16,819,200.00 | 15,932,700.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **2,409,826.00** |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **47,036,476.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **47,036,476.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 23,336,476.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 8,775,690.00 |
| 210102 | Нэмэгдэл | 1,899,910.00 |
| 210104 | Урамшуулал | 6,875,780.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 1,193,776.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 842,647.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 87,757.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 70,206.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 17,551.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 175,615.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 862,100.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 250,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 612,100.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 9,421,224.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 9,421,224.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,847,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,847,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 236,686.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 236,686.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 23,700,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 23,700,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 23,700,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **47,036,476.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 47,036,476.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 46,450,276.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 586,200.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баянмөнх сумын ЭМТ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Х.Еркегүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Оюунтуяа, дарга, тэргүүлэх аудитор Ч.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянмөнх сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 3/02 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Баянмөнх сумын ЭМТ нь эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээг амбулаторийн болон хэвтүүлэн эмчлэх үйл ажиллагаа явуулдаг, орон нутгийн харьяа байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянмөнх сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн

тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 380.7 сая төгрөгөөс 1 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Баянмөнх сумын ЭМТ-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 58.1 сая төгрөгөөр буюу 12.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1.0 | 2.0 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | 2,409.8 | 2,409.8 |
| Авлага | 461.5 | 40,807.3 | 40,345.8 |
| Урьдчилгаа | 784.0 | - | (784.0) |
| Бараа материал | 14,113.2 | 10,030.6 | (4,082.6) |
| Үндсэн хөрөнгө | 451,381.7 | 471,596.2 | 20,214.5 |
| **Нийт хөрөнгө** | **466,740.3** | **524,843.9** | **58,103.6** |
| Өр төлбөр | - | 33,825.3 | 33,825.3 |
| Засгийн газрын сан /Орон нутгийн сан | 316,754.9 | 316,754.9 | - |
| Өмнөх үеийн үр дүн | 58,895.1 | 58,895.1 | - |
| Тайлант оны үр дүн | | 24,278.2 | 24,278.2 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 91,090.3 | 91,090.3 | - |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **466,740.3** | **524,843.9** | **58,103.6** |
| Нийт орлого /Үр дүнгийн тайлан | 343,218.7 | 535,757.3 | 192,538.6 |
| Нийт зардал /Үр дүнгийн тайлан | 376,879.3 | 471,832.5 | 94,953.2 |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 2.4 сая төгрөг болж өссөн нь тайлант онд төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлээгүй байна.

Авлага дансны үлдэгдэл 40.3 сая төгрөг болж өссөн нь эрүүл мэндийн даатгалын сангаас авах санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 10.0 сая төгрөг болж 4.1 сая төгрөгөөр буурсан нь эрүүл мэндийн санхүүжилт тасарснаас шалтгаалж эм, хамгаалах хэрэгслийн худалдан авалт зогсож эмийн нөөц багассантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 471.6 сая төгрөг болж 20.2 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь дээд шатны байгууллагаас хөрөнгө үнэ төлбөргүй шилжиж ирсэн 53.7 сая төгрөг, батлагдсан төсвөөс 2.9 сая төгрөгийн худалдаж авсан үндсэн хөрөнгөөр нэмэгдэж, 29.3 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлж данснаас хассан байна.

Засгийн газрын сан дансны үлдэгдэл 316.7 сая төгрөг байна. Тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 535.7 сая төгрөг болж, өмнөх оноос 192.5 сая төгрөгөөр буюу 56.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө өссөнтэй холбоотой байна.

Нийт зардал 504.1 сая төгрөг болж, өмнөх оноос 127.3 сая төгрөгөөр буюу 33.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, норматив зардал, хангамж, бараа материалын зардал, урсгал шилжүүлэг зэрэг зардлууд байна. Энэ нь короновируст халдварын дэгдэлттэй холоотой илүү цагийн хөлс, урамшуулал, эм эмнэлгийн хэрэгсэл, хоол, эмч ажилчдад олгосон нэг удаагийн тэтгэмж, урамшуулал зэрэг зардлууд өссөнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тайлант онд орон нутгийн төсвөөс 26.8 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 16.8 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 351.8 сая төгрөг, нийт 395.4 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд тусгай зориулалтын шилжүүлгээс 386.8 сая төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 15.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 26.8 сая төгрөгийн орлого бүрдүүлж, үүнээс урсгал үйл ажиллагаанд 441.5 сая төгрөгийг зарцуулж, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдэл 7.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тухайн байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд ЭМДС-аас короновируст халдвараар хэвтэн эмчлүүлэгчдийн эмчилгээ, дархлаажуулалтын вакцины санхүүжилт 22.7 сая төгрөг, эрүүл мэндийн ажиллагсдад олгох нэг удаагийн тэтгэмжийн санхүүжилт 23.7 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 0.6 сая төгрөг, нийт 47.0 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт хамааралтай асуудал илрээгүй.

### 3.8 Аудитын гол асуудал

Байгууллагад төлөх 4.4 сая төгрөгийн эмийн өрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, цалингийн зардлыг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэдэггүйгээс санхүүгийн тайланд авлага 3.1 сая төгрөг, ХХОАТ-н өглөг 0.7 сая төгрөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 340.7 сая төгрөгийн 17 мэдээлэл, зарлагын 24.2 сая төгрөгийн 3 мэдээлэл, худалдан авалтын 45.3 сая төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүллээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны аудитаар 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн ба хэрэгжилт 67 хувь байна. Шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмж хэрэгжээгүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал бүртгэгдээгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 492.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 73.8 сая төгрөгийн алдааг залруулж, 418.4 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүллээ.

### 4.2.1 Залруулсан алдаа

1. Элэгдлийн зардлыг зөрүүтэй илэрхийлсэн 7.2 сая төгрөг, санхүүгийн тайланд тусгалгүй орхигдуулсан ЭМДС-аас авах 37.67 сая төгрөг, ажилчдад төлөх цалингийн өглөг 25.9 сая төгрөг, НДШ-ийн өглөг 3.0 сая төгрөг, нийт 73.8 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийв.

### 4.2.2 Албан шаардлага

1. Байгууллагад төлөх эмийн зардлын 4.4 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй;
2. Цалингийн зардлыг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэдэггүйгээс ажиллагчидтай холбоотой авлага 3.1 сая төгрөг, ХХОАТ-н өглөг 0.7 сая төгрөг, нийт 3.8 сая төгрөгийн санхүүгийн тайланд өр, авлага үүсгэсэн;
3. Шилэн дансны цахим хуудсанд таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 340.7 сая төгрөгийн 17 мэдээлэл, зарлагын 24.2 сая төгрөгийн 3 мэдээлэл, худалдан авалтын 45.3 сая төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй, нийт 410.2 сая төгрөгийн зөрчил илэрч, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчлийг арилгах 3 албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайлангийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Баянмөнх сумын Эрүүл мэндийн төв | 5 | 82.0 | 3 | 73.8 | | | 2 | 8.2 | | |
| **Дүн** | | **5** | **82.0** | **3** | **73.8** | | | **2** | **8.2** | | |
| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | | |
| 1 | Баянмөнх сумын Эрүүл мэндийн төв | 1 | 410.2 | | | | | 1 | 410.2 | | |
| **Дүн** | | **1** | **410.2** | | | | | **1** | **410.2** | | |
| **Нийт дүн** | | **6** | **492.2** | **3** | **73.8** | | | **3** | **418.4** | | |

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 Дугаар 05/А2370449 Чингис хот
ХЭА-2022/62/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянмөнх сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Цалингийн зардлыг анхан шатны баримтыг үндэслэн бүртгэдэггүйгээс санхүүгийн тайланд НДШ-д 2887.5 мянган төгрөг, лист илүү олгож суутган тооцоогүй 250.0 мянган төгрөгийн авлага, ХХОАТ-д 679.4 мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Цалингийн зардлын нягтлан бодох бүртгэлийг анхан шатны баримтыг үндэслэн хөтөлдөггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянмөнх сумын ЭМТ-ийн дарга С.Нансал, нягтлан бодогч Л.Баянмөнх нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Х.ЕРКЕГУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0048 9074082

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 Дугаар 06/12370449 ХЭА-2022/62/НА-СТА-ТШЗ Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянмөнх сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 340,737.6 мянган төгрөгийн 17 мэдээлэл, зарлагын 24,167.9 мянган төгрөгийн 3 мэдээлэл, худалдан авалтын 45,309.2 мянган төгрөгийн 4 мэдээллийг байршуулаагүй, өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”, 6.4.4-д ”таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;” 6.4.5-д “цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д “аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудсанд байршуулбал зохих мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, бүрэн мэдээлдэггүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянмөнх сумын ЭМТ-ийн дарга С.Нансал, нягтлан бодогч Л.Баянмөнх нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Х.ЕРКЕГУЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

Монгол Улс, Чингис хот, 3-р баг, Аймгийн Засаг даргын Тамгын газрын байр, Утас: 98601199

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

2022 оны 02 дугаар сарын 25 Дугаар 04/А2370449 ХЭА-2022/62/НА-СТА-ТШЗ Чингис хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянмөнх сумын ЭМТ-ийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагад төлөх 4,421.7 мянган төгрөгийн эмийн өрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.7 -д “авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллагад төлөх эмийн зардлын өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянмөнх сумын ЭМТ-ийн дарга С.Нансал, нягтлан бодогч Л.Баянмөнх нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТОР Х.ЕРКЕГҮЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ОЮУНТУЯА

2317144297
СЮА0046 9074082

023 40019